



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 24 өдөр

Дугаар A/138

Халбан

**Үнэлгээний хороо байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 103 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цэцэрлэг сумын Орон нутгийн хөгжлийн сангаар санхүүжигдэх 24,000,000 (хорин дөрвөн сая) төгрөгийн өртөгтэй “Эрүүл мэндийн төвд суудлын жижиг автомашин (Toyota Probox) худалдан авах” ажлын гүйцэтгэгч сонгох үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: М.Ренчиндорж (Засаг даргын Тамгын газрын Нярав)

Гишүүд: Н.Ганжуур (Татварын Улсын байцаагч)

Т.Оюунсайхан (Иргэний төлөөлөл)

Ч.Бямбасүрэн (Хөдөө аж ахуйн тасгийн

мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: С.Долгоржав (Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрын багш)

2.Худалдан авах ажиллагааг хууль, журам, батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (М.Ренчиндорж)-д даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Бямбажав)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Н.АНХБАЯР



БАТЛАВ:  
ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГА /М.АНХБАЯР/



**Цэцэрлэг сум Эрүүл мэндийн төвд худалдан авах  
Toyota Probox суудлын авто машины техникийн  
тодорхойлолт**

№		Үзүүлэлт
1	Мотор багтаамж	1.5 л
2	Хурдны хайрцаг	Автомат
3	Хүрд	Буруу
4	Төрөл	Суудлын тэрэг
5	Өнгө	Цагаан
6	Үйлдвэрлэсэн он	2016
7	Орж ирсэн он	2022-2023
8	Хөдөлгүүр	Бензин
9	Дотор өнгө	Цагаан
10	Хөтлөгч:	Бүх дугуй 4WD
11	Явсан км	150000 км ихгүй байх
12	Хаалга:	5